



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Мэргэжлийн хяналтын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ГАА-2022/66/-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Говь-Алтай аймаг Алтай хот 2021 он	Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр Утас: 70483413 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 70484055 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn Ахлах аудитор: Б.Цэцэгмаа Утас: 99488754 Цахим хаяг: tsetsegmaab@audit.gov.mn
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	12
3. Аудитын тайлан	13
3.1 Ерөнхий зүйл	13
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Материаллаг байдал	14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	15
3.8 Аудитын гол асуудал	16
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
4. Аудитын илрүүлэлт	16
4.1 Залруулсан алдаа	16
4.2 Төлбөрийн акт	17
4.3 Албан шаардлага	17
4.4 Зөвлөмж	17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН
ГАЗРЫН ДАРГА Н.СУМЪЯАБАЗАР
ТАНАА

**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

9018301, Говь-Алтай аймаг,
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
E-mail: govialtai@audit.gov.mn

2022.02.25

№

67

танай _____ -ны № _____ -т

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Мэргэжлийн хяналтын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Мэргэжлийн хяналтын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.ТҮВШИНБАЯР



07020273

SECRET



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/ төгрөгөөр /			
Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	108,847,810.17	105,108,201.50
33	АВЛАГА	0	322,130.00
33500	Бусад авлага	0	322,130.00
33510	Байгууллагаас авах авлага	0	322,130.00
35	БАРАА МАТЕРИАЛ	108,847,810.17	104,786,071.50
35100	Түүхий эд материал	22,649,388.90	20,540,517.79
35110	Тусгай зориулалттай материал	5,590,074.04	5,175,238.12
35130	Эм боох материал	17,059,314.86	15,365,279.67
35400	Хангамжийн материал	86,198,421.27	84,245,553.71
35410	Бичиг хэргийн материал	5,294,671.56	4,157,682.06
35420	Аж ахуйн материал	21,555,463.98	14,838,440.93
35440	Түлш, шатах тослох материал	7,629,225.00	2,985,873.00
35470	Бусад хангамжийн материал	51,719,060.73	62,263,557.72
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,544,275,515.71	1,489,502,628.82
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,544,275,515.71	1,489,502,628.82
39200	Биет хөрөнгө	1,496,515,285.99	1,441,945,518.12
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,406,651,478.00	1,406,651,478.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-69,077,779.88	-117,723,490.70
39203	Авто-тээврийн хэрэгсэл	126,650,000.00	126,650,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-81,085,834.39	-91,030,643.53
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	289,084,698.84	319,292,698.84
39206	Хуримтлагдсан элэгдэл	-214,401,469.37	-242,035,907.77
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	41,524,856.80	51,024,856.80
39208	Хуримтлагдсан элэгдэл	-23,500,496.73	-26,713,489.22
39214	Бусад үндсэн хөрөнгө	34,390,271.00	34,390,271.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-13,720,438.28	-18,560,255.30
39300	Биет бус хөрөнгө	47,760,229.72	47,557,110.70
39301	Програм хангамж	1,440,800.00	1,440,800.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-880,570.28	-1,083,689.30
39303	Бусад биет бус хөрөнгө	47,200,000.00	47,200,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,653,123,325.88	1,594,610,830.32
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0	322,130.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0	322,130.00
41300	Өглөг	0	322,130.00
41360	Бусад өглөг	0	322,130.00
41361	Байгууллагад төлөх өглөг	0	322,130.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,653,123,325.88	1,594,288,700.32
51	Засгийн газрын хувь оролцоо	1,653,123,325.88	1,594,288,700.32
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	303,997,245.08	303,997,245.08
51200	Хуримтлагдсан үр дүн	1,226,419,973.38	1,167,585,347.82
51210	Өмнөх үеийн үр дүн	-148,891,261.90	1,226,419,973.38
51220	Тайлант үеийн үр дүн	1,375,311,235.28	-58,834,625.56
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	122,706,107.42	122,706,107.42
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,653,123,325.88	1,594,610,830.32

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

		/ төгрөгөөр /	
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,407,256,783.00	957,834,995.31
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,348,235,273.00	16,714,495.31
120	Нийтлэг татварын бус орлого	1,348,235,273.00	16,714,495.31
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4,290,500.00	5,214,400.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,290,500.00	5,214,400.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	1,330,456,123.00	1,500,000.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	13,488,650.00	10,000,095.31
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,059,021,510.00	941,120,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,016,863,100.00	930,088,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,016,863,100.00	930,088,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	42,158,410.00	11,032,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	6,222,000.00	0
131103	ЗГНХ ЗДНХ хөрөнгө, түүнтэй адилтах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	13,269,410.00	10,280,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	19,700,000.00	752,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,967,000.00	0
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,031,945,547.72	1,016,669,620.87
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,031,945,547.72	1,016,669,620.87
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	984,345,307.92	1,002,684,707.57
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	603,262,521.20	594,461,461.70
210101	Үндсэн цалин	451,980,328.00	451,116,561.70
210102	Нэмэгдэл	119,659,898.00	124,952,900.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	18,392,000.00	18,392,000.00
210104	Урамшуулал	13,230,295.20	0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	78,760,800.00	77,582,792.00
210201	Тэтгэврийн даатгал	55,424,300.00	54,246,292.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,834,100.00	5,834,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,667,400.00	4,667,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,166,800.00	1,166,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	11,668,200.00	11,668,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	73,946,110.00	61,118,485.00
210301	Гэрэл, цахилгаан	3,478,284.00	4,217,369.00
210302	Түлш, халаалт	66,744,230.00	53,317,440.00
210303	Цэвэр, бохир ус	3,223,596.00	3,083,676.00
210304	Байрны түрээс	500,000.00	500,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	57,343,074.85	75,687,783.64
210401	Бичиг хэрэг	8,834,820.26	6,418,634.81
210402	Тээвэр, шатахуун	26,469,867.00	30,243,007.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,164,597.00	7,163,912.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	14,873,790.59	15,357,758.77
210408	Бараа материал акталсны зардал	0	16,504,471.06
2105	Нормативт зардал	9,929,582.95	20,668,061.11
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	6,114,147.95	16,086,391.11
210502	Хоол, хүнс	3,272,435.00	4,241,670.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	543,000.00	340,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	21,994,250.00	26,170,746.23
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	0	13,384,806.23
210604	Урсгал засвар	21,994,250.00	12,785,940.00
2107	Томилолт, зочны зардал	34,271,300.00	32,803,500.00
210702	Дотоод албан томилолт	34,271,300.00	32,803,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,664,330.00	18,610,991.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,395,600.00	14,323,360.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	100,000.00	166,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,800,000.00	1,199,750.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	264,500.00	306,731.00

Мэргэжлийн хяналтын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	110,000.00	110,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	990,000.00	1,210,000.00
210807	Газрын төлбөр	104,680.00	95,500.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	899,550.00	1,199,650.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	92,173,338.92	95,580,886.89
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,667,502.00	1,100,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	90,505,836.92	94,480,886.89
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	47,600,239.80	13,984,913.30
2132	Бусад урсгал шилжүүлэг	43,218,600.00	6,900,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	24,018,600.00	0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	19,200,000.00	6,900,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,381,639.80	7,084,913.30
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	91,139.80	1,870,513.30
213306	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг	4,290,500.00	5,214,400.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	1,375,311,235.28	-58,834,625.56
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	1,375,311,235.28	-58,834,625.56

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	/ төгрөгөөр /
					Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	303,997,245.08	122,706,107.42	-148,891,261.90	277,812,090.60
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	0	0
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	303,997,245.08	122,706,107.42	-148,891,261.90	277,812,090.60
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	0	0	0
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0	0	0	0
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0	0	0	0
7	Өмчид гарсан өөрчилөлт	0	0	0	0
8	Зарласан ногдол ашиг	0	0	0	0
9	Тайлант үеийн үр дүн	0	0	1,375,311,235.28	1,375,311,235.28
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	303,997,245.08	122,706,107.42	1,226,419,973.38	1,653,123,325.88
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	303,997,245.08	122,706,107.42	1,226,419,973.38	1,653,123,325.88
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	0	0
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	303,997,245.08	122,706,107.42	1,226,419,973.38	1,653,123,325.88
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	0	0	0
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0	0	0	0
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0	0	0	0
17	Өмчид гарсан өөрчилөлт	0	0	0	0
18	Зарласан ногдол ашиг	0	0	0	0
19	Тайлант үеийн үр дүн	0	0	-58,834,625.56	-58,834,625.56
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	303,997,245.08	122,706,107.42	1,167,585,347.82	1,594,288,700.32

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

		/ төгрөгөөр /	
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,063,312,010.00	946,334,900.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,290,500.00	5,214,400.00
120	Нийтлэг татварын бус орлого	4,290,500.00	5,214,400.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4,290,500.00	5,214,400.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,290,500.00	5,214,400.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,059,021,510.00	941,120,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,016,863,100.00	930,088,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,016,863,100.00	930,088,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	42,158,410.00	11,032,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	6,222,000.00	0
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	13,269,410.00	10,280,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	19,700,000.00	752,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,967,000.00	0
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	997,793,560.00	908,126,900.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	997,793,560.00	908,126,900.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	950,193,320.20	894,141,986.70
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	603,262,521.20	594,461,461.70
210101	Үндсэн цалин	451,980,328.00	451,116,561.70
210102	Нэмэгдэл	119,659,898.00	124,952,900.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	18,392,000.00	18,392,000.00
210104	Урамшуулал	13,230,295.20	0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	78,760,800.00	77,582,792.00
210201	Тэтгэврийн даатгал	55,424,300.00	54,246,292.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,834,100.00	5,834,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,667,400.00	4,667,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,166,800.00	1,166,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	11,668,200.00	11,668,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	73,946,110.00	61,118,485.00
210301	Гэрэл, цахилгаан	3,478,284.00	4,217,369.00
210302	Түлш, халаалт	66,744,230.00	53,317,440.00
210303	Цэвэр, бохир ус	3,223,596.00	3,083,676.00
210304	Байрны түрээс	500,000.00	500,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	59,751,657.00	46,284,327.00
210401	Бичиг хэрэг	9,657,500.00	5,133,560.00
210402	Тээвэр, шатахуун	32,225,960.00	25,599,655.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,164,597.00	7,163,912.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,703,600.00	8,387,200.00
2105	Нормативт зардал	22,736,300.00	18,402,490.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	18,920,865.00	13,820,820.00
210502	Хоол, хүнс	3,272,435.00	4,241,670.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	543,000.00	340,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	63,132,800.00	43,777,940.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	583,000.00	292,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	40,555,550.00	30,700,000.00
210604	Урсгал засвар	21,994,250.00	12,785,940.00
2107	Томилолт, зочны зардал	34,271,300.00	32,803,500.00
210702	Дотоод албан томилолт	34,271,300.00	32,803,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,664,330.00	18,610,991.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,395,600.00	14,323,360.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	100,000.00	166,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,800,000.00	1,199,750.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	264,500.00	306,731.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	110,000.00	110,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	990,000.00	1,210,000.00
210807	Газрын төлбөр	104,680.00	95,500.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	899,550.00	1,199,650.00

Мэргэжлийн хяналтын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,667,502.00	1,100,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,667,502.00	1,100,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	47,600,239.80	13,984,913.30
2132	Бусад урсгал шилжүүлэг	43,218,600.00	6,900,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	24,018,600.00	0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	19,200,000.00	6,900,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,381,639.80	7,084,913.30
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	91,139.80	1,870,513.30
213306	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг	4,290,500.00	5,214,400.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	65,518,450.00	38,208,000.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	65,518,450.00	38,208,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	65,518,450.00	38,208,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	65,518,450.00	38,208,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	65,518,450.00	38,208,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-65,518,450.00	-38,208,000.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	0	0
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	0
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	0
100	Тохируулгын орлого, зарлагын зөрүү	0	0

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

			/ төгрөгөөр /
Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	930,088,500.00	928,217,986.70
21	УРСГАЛ ЗАРДАЛ	930,088,500.00	928,217,986.70
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	923,188,500.00	921,317,986.70
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	594,462,000.00	594,461,461.70
210101	Үндсэн цалин	451,117,100.00	451,116,561.70
210102	Нэмэгдэл	124,952,900.00	124,952,900.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	18,392,000.00	18,392,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	79,253,400.00	77,582,792.00
210201	Тэтгэврийн даатгал	55,916,900.00	54,246,292.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,834,100.00	5,834,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,667,400.00	4,667,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,166,800.00	1,166,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	11,668,200.00	11,668,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	61,231,100.00	61,118,485.00
210301	Гэрэл, цахилгаан	4,211,900.00	4,217,369.00
210302	Түлш, халаалт	53,319,000.00	53,317,440.00
210303	Цэвэр, бохир ус	3,200,200.00	3,083,676.00
210304	Байрны түрээс	500,000.00	500,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	45,786,100.00	45,784,327.00
210401	Бичиг хэрэг	5,159,400.00	5,133,560.00
210402	Тээвэр, шатахуун	25,100,200.00	25,099,655.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,164,600.00	7,163,912.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,361,900.00	8,387,200.00
2105	Нормативт зардал	16,413,900.00	16,410,490.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	13,820,900.00	13,820,820.00
210502	Хоол, хүнс	2,250,000.00	2,249,670.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	343,000.00	340,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	73,986,400.00	73,985,940.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	30,500,000.00	30,500,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	30,700,000.00	30,700,000.00
210604	Урсгал засвар	12,786,400.00	12,785,940.00
2107	Томилолт, зочны зардал	32,272,100.00	32,263,500.00
210702	Дотоод албан томилолт	32,272,100.00	32,263,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	18,683,500.00	18,610,991.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	14,338,400.00	14,323,360.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	169,600.00	166,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,200,000.00	1,199,750.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	360,000.00	306,731.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	110,000.00	110,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,210,000.00	1,210,000.00
210807	Газрын төлбөр	95,500.00	95,500.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,200,000.00	1,199,650.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,100,000.00	1,100,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,100,000.00	1,100,000.00

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,900,000.00	6,900,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,900,000.00	6,900,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,900,000.00	6,900,000.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	930,088,500.00	928,217,986.70
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	930,088,500.00	928,217,986.70
310001	Улсын төсвөөс санхүүжих	930,088,500.00	928,217,986.70

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

		/ төгрөгөөр /
Код	Үзүүлэлт	Тайлант оны гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	11,032,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,032,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,032,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	500,000.00
210402	Тээвэр, шатахуун	500,000.00
2105	Нормативт зардал	1,992,000.00
210502	Хоол, хүнс	1,992,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,000,000.00
210602	Тавилга	8,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	540,000.00
210702	Дотоод албан томилолт	540,000.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	11,032,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	11,032,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,280,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	752,000.00
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Мэргэжлийн хяналтын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах, зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Цэцэгмаа гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Ж.Бүжинханд, аудитын менежер Д.Эрдэнэчимэг, дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Мэргэжлийн хяналтын газар нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 19-ны өдрийн 01/20 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Мэргэжлийн хяналтын газар нь төрийн хяналт шалгалт хийх чиг үүрэгтэй Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын харьяа байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Мэргэжлийн хяналтын газрын дотоод хяналт, хяналт-шинжилгээ үнэлгээний нэгж нь тайлант онд 6 бүлэг 29 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөгөө батлуулж 2020 оны санхүүгийн үйл ажиллагаа, шилэн дансны нэгдсэн системд байршуулсан мэдээлэл, бусад ажил үйлчилгээний чанарт үнэлэлт өгсөн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Мэргэжлийн хяналтын газар нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардал болох 1,031.9 сая төгрөгөөс 2 хувиар буюу 20.6 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 16.5 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг АДБОУС 2320-н 13-д заасны дагуу аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн тайлангийн нийт зардлын дүн болох 1,015.9 сая төгрөгөөс 2 хувиар буюу 20.3 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг гүйцэтгэлийн материаллаг байдлын 80 хувиар буюу 16.2 сая төгрөгөөр тогтоосон.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Мэргэжлийн хяналтын газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 4 хувиар буюу 58.8 сая төгрөгөөр буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өглөгийн данс байна.

Тайлант онд 5.2 сая төгрөгийн үндсэн үйл ажиллагааны орлого, 930.1 сая төгрөгийн санхүүжилт, 11.0 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт нийт 946.3 сая төгрөг эх үүсвэр бүрдүүлж оны эцэст 1.8 сая төгрөгийн хэмнэлтийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн буюу 2021 оны эцэст мөнгөн хөрөнгийн үлдэгдэлгүй байна.

Авлага дансны үлдэгдэл 0.3 сая төгрөг болж өссөн нь татварын тодорхойлолтоор үүссэн бөгөөд харилцагч байгууллагын данс андуурснаас шалтгаалсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 104.8 сая төгрөг болж 4.1 сая төгрөгөөр буурсан нь ковид-19 цар тахлын онцгой нөхцөл байдал үүсэж зарцуулалт нэмэгдсэнтэй холбоотой байна. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 94.4 сая төгрөгийн, үнэ төлбөргүйгээр 0.5 сая төгрөгийн, дээд байгууллагаасаа 8.9 сая төгрөгийн бараа материал бэлтгэж бараа материалын данс хооронд 0.8 сая төгрөгийн шилжүүлэх гүйлгээ хийсэн ба үйл ажиллагаандаа 91.3 сая төгрөгийн материалыг зарцуулж, 16.5 сая төгрөгийн бараа материалыг акталж данс бүртгэлээс хассан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,986.6 сая төгрөг болж 39.7 сая төгрөгөөр өссөн байна. Төсвийн хөрөнгөөр 38.2 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэж, 1.5 сая төгрөгийн тавилга хэрэгслийг үнэ төлбөргүйгээр хүлээн авчээ.

Өр төлбөрийн дансны үлдэгдэл 0.3 сая төгрөг болж 0.3 сая төгрөгөөр өссөн нь татварын тодорхойлолтоор үүссэн бөгөөд харилцагч байгууллагын данс андуурснаас шалтгаалсан байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 1,594.3 сая төгрөг болж 58.8 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ. Орлого өмнөх оноос 40 хувиар буюу 1,450.1 сая төгрөгөөр буурсан байна. Буурсан үндсэн шалтгаан нь тус байгууллага өмнөх онд шинэ байранд орж үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгийн орлогод тухайн байрыг бүртгэсэнтэй холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй ба тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл 1,167.6 сая төгрөг болсон байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,508.2 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 578.1 сая төгрөгөөр бууруулж, 930.1 сая төгрөгөөр баталжээ. Төсвийн төсөл өмнөх оны батлагдсан төсвөөс өндөр байгаа нь цалингийн зардал, байр ашиглалттай холбоотой зардал нэмэгдсэнтэй холбоотой байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсөв захирагчийн Мэргэжлийн хяналт хөтөлбөрийн хүрээнд 4 арга хэмжээг улсын төсвөөс санхүүжүүлэхээр 930.1 сая төгрөгийн төсөв баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 930.1 сая төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 928.2 сая төгрөгийг зарцуулж 1.8 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 928.2 сая төгрөг буюу 99.8 хувьтай байгаа нь ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл зардлын зүйл ангийг 1.7 сая төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 0.1 сая төгрөгөөр, тус тус хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар 11.0 сая төгрөгийн орлого хүлээн авсан ба ЗГНХ,ЗДНХ хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө ангилалд 10.3 сая төгрөг, Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 0.7 сая төгрөгийн орлогыг тайлагнасан. Нэмэлт санхүүжилтийн орлогоос 0.5 сая төгрөгийг тээвэр шатахуунд, 2.0 сая төгрөгийг хоол хүнсэнд, 8.0 сая төгрөгийг тавилга хэрэгсэл бэлтгэхэд, 0.5 сая төгрөгийг дотоод албан томилолтын зардалд зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Мэргэжлийн хяналтын газар нь 2021 онд нийт 1,051.0 сая төгрөгийн 148 мэдээллийг Шилэн дансны цахим хуудсанд ил тод байршуулахаас 0.3 сая төгрөгийн 2 мэдээллийг байршуулаагүй 625.5 сая төгрөгийн 98 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн өр, авлага үүсгэсэн 0.3 сая төгрөгийг мэдээлээгүй нь шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл 6.4-т “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ”, 6.4.8-т “Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр” заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 0.6 сая төгрөгийн төлбөрийн акт, 6.8 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага, 0.5 сая төгрөгийн зөвлөмж хүргүүлснийг биелүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар батлагдсан орон тоо бүтцийг мөрдөж байгаа байдал, Төрийн албаны зөвлөлийн шалгалтаар төрийн албаны тухай хууль зөрчиж томилогдсон 2 албан тушаалтан байгаа байдал, авлага өглөгийн бүртгэл, тайлагналт, тээвэр шатахууны зардалд худалдан авах ажиллагаа зохион байгуулж бэлтгэн нийлүүлэгчийг сонгосон боловч тос тосолгооны материалын худалдан авалтыг тендерт шалгарсан оролцогчоос хийгээгүй байдал, албан хэрэгцээнд ашигладаг 63 54 ГАҮ улсын дугаартай ланд 105 маркийн албаны автомашины заалт 349 километр тасарсан байхад хувийн хэрэгт тэмдэглээгүй байсан тул автомашины ашиглалтын байдлыг тус тус анхаарах шаардлагатай.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 81.0 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 12.5 сая төгрөгийн алдааг залруулж, 0.2 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 68.3 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах 1 зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар тайлант онд 12.2 сая төгрөгийн худалдан авалтын гүйлгээ төлбөрийн баримтын нэгдсэн системийн баримтын жагсаалтын худалдан авалт төрөлд бүртгэгдээгүй, татварын

тодорхойлолтоор байгууллагад төлөх 0.3 сая төгрөгийн өглөг авлагатай байсныг илрүүлж аудитын хугацаанд нөхөн шивүүлж залруулсан.

4.2 Төлбөрийн акт

Шатахууны тооцоог давтан хийхэд 0.2 сая төгрөгийн шатахууныг анхан шатны баримтгүйгээр зарцуулснаар тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо.

4.3 Албан шаардлага

Татварын тодорхойлолтоор 0.1 сая төгрөгийн дутуу төлөлттэй боловч санхүүгийн тайланд тусгаагүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Батлагдсан орон тооноос төрийн захиргаа, удирдлагын хэлтэст 4 орон тоо илүү ажиллуулж түүнд 37.5 сая төгрөгийн цалингийн сан зарцуулсан нь Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын 2021 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн А/105 дугаар тушаал, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3-т "Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Босго үнээс давсан төсөв батлагдсан хөдөлмөр хамгааллын хэрэгслийн 30.7 сая төгрөгийн зардалд худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй нь Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

4.4 Зөвлөмж

Аудитаар шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

- 1.1. Илрүүлэлт: Тайлант онд бүртгэгдсэн 0.3 сая төгрөгийн өр, авлагыг бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр хэсэгт мэдээлээгүй, харилцагч байгууллагатай тооцоо нийлэх асуудалд дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй байна.
- 1.2. Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн 6.4-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.8-т "Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр" гэсэн заалтыг мөрдөн ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү. Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

№	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Мэргэжлийн хяналтын газар	7	43.5	2	12.5	1	0.2	3	30.8	1	